



МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

2019 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2019 оны 2 дугаар улиралд 305 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 509 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 236 сая ам.долларын ашигтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 32 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 47 сая ам.доллараар буурч, санхүүгийн дансны ашиг 154 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 4,101 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 6.7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1%-иар өсч 3,638 сая ам.долларт хүрсэн ба худалдааны тэнцэл 440 сая ам.долларын ашигтай гарсан.

Тодруулбал, экспортын хувьд, төмрийн хүдрийн экспорт 53 сая ам.доллараар (58%), ноолуурын экспорт 23 сая ам.доллараар (11%), түүнчлэн СИФ нөхцөлөөр тооцсон хэрэглээний бүтээгдэхүүний импорт 30 сая ам.доллараар (7%), хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 15 сая ам.доллараар (2%) тус тус өссөн. Улмаар барааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 46 сая ам.доллараар өсчээ.

Үйлчилгээний худалдаа

2019 оны 2 дугаар улирлын гүйцэтгэлээр үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 14%-иар буюу 62 сая ам.доллараар буурч 374 сая ам.долларт хүрсэн.

Үүнд бусад үйлчилгээний алдагдал 175 сая ам.доллар болон тээврийн үйлчилгээний алдагдал 131 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 436 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 19%-иар буюу 69 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

2019 оны 2 дугаар улиралд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 102 сая ам.доллар, ногдол ашигт 58 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 179 сая ам.доллар болон арилжааны банкууд харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 1 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

Хоёрдогч орлого


Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2019 оны 2 дугаар улиралд Монгол улс нийт 40 сая ам.доллар буюу өнгөрсөн оны мөн үеэс 28 сая ам.доллараар бага орлогыг хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оны мөн үеэс 4%-иар буурсан бол гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 63%-иар өссөн, цэвэр дүнгээр 26 сая ам.долларын орлого авсан.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 9 сая ам.доллараар буурсан байна.


Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл



Дүрслэл 2. Барааны худалдаа



Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа



Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2019, II улирал (мян ам.доллар)

		Хүлээн авсан		Өсөлт	Шилжүүлсэн		Өсөлт		
		Мөнгөн дүн	Хувийн жин		Мөнгөн дүн	Хувийн жин			
Солонгос	KR	29,980	44%	▼	-12%	7,871	19%	▲	222%
Америк	US	6,882	10%	▼	-31%	5,274	13%	▲	38%
Хятад	CN	278	0%	▼	-50%	971	2%	▼	-31%
Гонг Конг	HK	919	1%	▲	6%	559	1%	▲	310%
Англи	GB	759	1%	▼	-26%	1,900	5%	▲	80%
ОХУ	RU	10,609	16%	▲	1453%	10,616	26%	▲	368%
Сингапур	SG	1,579	2%	▲	100%	1,522	4%	▼	-7%
Швейцарь	CH	1,881	3%	▲	55%	284	1%	▲	74%
Герман	DE	2,210	3%	▲	47%	668	2%	▼	-35%
Япон	JP	1,315	2%	▲	10%	1,398	3%	▲	69%
Бусад		11,376	17%	▲	7%	10,509	25%	▼	-12%
НИЙТ		67,788	100%			41,574	100%		

Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2019 оны 2 дугаар улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 736 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 250 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 486 сая ам.долларын орох урсгалтай байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 117 сая ам.доллараар өссөн байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь авч үзвэл:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 85 сая ам.доллараар өсч 415 сая ам.доллар,
- Сингапур улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 42 сая ам.доллараар өсч 43 сая ам.долларт хүрсэн бол,
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 55 сая ам.доллараар буурч 24 сая ам.доллар,
- Люксембург улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 40 сая ам.доллараар буурч 8 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

- Бөөний болон жижиглэн худалдааны салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 67 сая ам.доллараар,
- Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбар 32 сая ам.доллараар,
- Барилгын салбар 22 сая ам.доллараар өсч,
- Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 10 сая ам.доллараар,
- Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбар 7 сая ам.доллараар
- Уул уурхайн салбар 8 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2019 оны 2 дугаар улиралд 18 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 256 сая ам.доллараар өссөн байна.

Тайлант хугацааны голлох ажил гүйлгээг дурдвал:

- МИК 300 сая ам.долларын бонд гаргасан,
- Хуралдай бондын хүүгийн төлбөрт 26 сая ам.доллар,
- Энержи ресурс ХХК-ийн бондын хүүгийн төлбөрт 16 сая ам.долларыг эдийн засгийн харьяат буст тус тус төлжээ.

Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд болох арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны зэрэг бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр 25 сая ам.долларын орох урсгалтай байсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 301 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм. Энэхүү өөрчлөлтөд арилжааны банкуудын харилцах хадгаламжийн данс буурсан нь голлон нөлөөлсөн байна.


Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	2019		2019.II/18.II
		Дүн	Хувийн жин	Өөрчлөлт
1	Австрали	4	1%	1 ▲
2	Америк	51	7%	13 ▲
3	Англи	28	4%	18 ▲
4	БНХАУ	24	3%	-55 ▼
5	Герман	14	2%	14 ▲
6	Нидерланд	1	0%	-1 ▼
7	Хонг-Конг	45	6%	5 ▲
8	Канад	415	56%	85 ▲
9	Люксембург	8	1%	-40 ▼
10	ОХУ	5	1%	3 ▲
11	Сингапур	43	6%	42 ▲
12	Солонгос (өмнөд)	5	1%	2 ▲
13	Турк	1	0%	1 ▲
14	Франц	5	1%	5 ▲
15	Япон	37	5%	4 ▲
16	Бусад	50	7%	18 ▲
Нийт		736	100%	117 ▲


Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	II улирал		2019.II/18.II
		2018	2019	Өөрчлөлт
1	Барилга	0	22	22 ▲
2	Боловсрол	0	1	0 ▲
3	Боловсруулах үйлдвэрлэл	3	10	7 ▲
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	16	83	67 ▲
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	10	9	0 ▼
6	Мэдээлэл, холбоо	5	0	-4 ▼
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1	33	32 ▲
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	54	48	-7 ▼
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1	7	6 ▲
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	12	29	17 ▲
11	Уул уурхай, олборлолт	479	471	-8 ▼
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	22	12	-10 ▼
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6	6	1 ▲
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1	2	2 ▲
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1	0	0 ▼
16	Бусад	9	1	-8 ▼
Нийт		619	736	117 ▲

Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)



Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт



II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2019 оны 2 дугаар улиралд цэвэр дүнгээр 34,442 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 6,854 сая ам.доллар байна. Үүний 60%-ийг гадаад валютын албан нөөц, 28%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 8%-ийг шууд хөрөнгө оруулалт, 4%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 41,296 сая ам.долларт хүрчээ. Үүний 51%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 36%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 5%-иар буюу 1,674 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг

- Ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 21%-иар буюу 1,207 сая ам.доллараар, гадаад пассив 7%-иар буюу 2,881 сая ам.доллараар тус тус өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 2,020 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын позиц 849 сая ам.доллараар, албан нөөц 1,104 сая ам.доллараар тус тус өсч, бусад хөрөнгө оруулалтын позиц 66 сая ам.доллараар буурснаар тайлбарлагдаж байна.
- Тайлант улирлын позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар -272 сая, ханшийн өөрчлөлтөөр 117 сая, бусад өөрчлөлтөөр 66 сая, үнийн өөрчлөлтөөр 229 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 54%-ийг буюу 11,525 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 9,659 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 6,797 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 32%,
- БНХАУ-аас 4,867 сая ам.доллар буюу 23%,
- Сингапур улсаас 1,667 сая ам.доллар буюу 8%,
- Люксембург улсаас 1,338 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 6%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг манай улсад тус тус оруулсан байна.

Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2019 оны 2 дугаар улиралд 292 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 3%-иар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 5,231 сая ам.долларт хүрч 6%-иар өссөн үзүүлэлттэй байна.


Актив: Эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Хонг-Конг 35%, АНУ 17%, Сингапур 11%, Австрали 8%, Их Британ 7%-ийг тус тус эзэлж байна.

Пассив: Эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал АНУ 15%, Их Британ 7%, Люксембург 5%, Сингапур 3%, Хонг Конг 3%, үлдсэн 57% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа учраас хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй байна.


Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	6/31/2018	6/31/2019	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-32,768	-34,442	1,674	5%
I. Гадаад актив	5,647	6,854	1,207	21%
1. Шууд хөрөнгө оруулалт	521	564	44	8%
2. Багцын хөрөнгө оруулалт	275	292	17	6%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	06	05	-01	-13%
4. Бусад хөрөнгө оруулалт	1,856	1,899	43	2%
5. Нөөц актив	2,989	4,094	1,104	37%
II. Гадаад пассив	38,415	41,296	2,881	7%
1. Шууд хөрөнгө оруулалт	19,121	21,184	2,063	11%
2. Багцын хөрөнгө оруулалт	4,394	5,260	866	20%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	25	00	-25	-100%
4. Бусад хөрөнгө оруулалт	14,875	14,852	-23	0%


Дүрслэл 6. Гадаад актив, пассив



Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2019 он



Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2019 он



III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2019 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 29,693 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 2,032 сая ам.доллараар өссөн байна.

Улсын салбар: Засгийн газрын гадаад өр 317 сая ам.доллараар өсч 7,246 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 31 сая ам.доллараар буурч 2,034 сая ам.долларт хүрчээ.

Бусад салбар: Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,746 сая ам.доллараар өсч 20,413 сая ам.долларт хүрээд байна.

Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2019 оны 2 дугаар улирлын эцэст 2,245 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 66 сая ам.доллараар буурчээ.

Гадаад өрийн 40%-ийг урт хугацаат зээл, 28%-ийг бонд өрийн бичиг, 17%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 15%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 891 сая ам.доллар, 383 сая ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна.

Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2019 оны 2 дугаар улирлын эцэст 18,168 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,812 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 53% буюу 9,659 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.


Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 288 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)


Үзүүлэлт	6/30/2018	6/30/2019	өөрчлөлт		* %
			дүн	хувь	
Нийт гадаад өр	27,661	29,693	2,032	7%	100%
I. Засгийн газар	6,929	7,246	317	5%	24%
Бонд, өрийн бичиг	2,996	2,941	-55	-2%	
Зээл	3,933	4,306	372	9%	
II. Төв банк	2,065	2,034	-31	-1%	7%
III. Банк	2,311	2,244.8	-66	-3%	8%
Богино хугацаат	777	722	-55	-7%	2%
Урт хугацаат	1,534	1,523	-11	-1%	5%
IV. Бусад сектор	7,895	8,509	613	8%	29%
Богино хугацаат	647	662	15	2%	2%
Урт хугацаат	7,248	7,847	598	8%	26%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	8,461	9,659	1,198	14%	33%

*: Нийт өсөлтөд оруулсан хувь

Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл



Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	II улирал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2017	2018	2019	Дүн	2018/17	Дүн	2019/18
I. УРСГАЛ ДАНС	-120	-379	-329	-259	-215%	50	13%
Бараа ба үйлчилгээний худалдаа	270	-80	66	-350	-130%	146	183%
Кредит	1,930	2,267	2,376	337	17%	109	5%
Дебет	1,660	2,347	2,310	687	41%	-37	-2%
1. Бараа	527	355	440	-171	-33%	85	24%
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,683	1,981	2,039	299	18%	58	3%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	1,156	1,626	1,599	470	41%	-27	-2%
2. Үйлчилгээ	-257	-435	-374	-179	-70%	62	14%
Кредит	247	285	337	38	15%	51	18%
Дебет	504	721	711	217	43%	-10	-1%
2.1 Тээвэр	-89	-158	-131	-70	-79%	27	17%
Кредит	84	101	137	16	19%	36	36%
Дебит	173	259	268	86	50%	9	4%
2.2 Аялал	-16	-70	-68	-54	-326%	2	3%
Кредит	98	111	126	13	14%	15	13%
Дебит	114	181	194	67	59%	13	7%
2.3 Бусад үйлчилгээ	-152	-207	-175	-56	-37%	32	16%
Кредит	65	74	74	9	13%	0	0%
Дебит	217	281	249	64	30%	-32	-11%
3 Анхдагч орлого	-430	-367	-436	64	15%	-69	-19%
Кредит	20	89	97	69	346%	8	9%
Дебет	450	455	532	5	1%	77	17%
3.1 Ажилчдын цалин	-9	47	47	56	593%	1	2%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-422	-419	-485	3	1%	-66	-16%
3.3 Бусад	1	6	2	4		-3	-60%
4 Хоёрдогч орлого	40	68	40	28	70%	-8	-41%
Кредит	62	95	84	33	52%	-12	-12%
Дебит	23	28	44	5	21%	16	58%
Үүнээс: Хувийн гуйвуулга	3	11	6	8	254%	-5	-42%
II. ХӨРӨНГ ИЙН ДАНС	14	27	24	13	95%	-2	-9%
1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/бууралт	0	0	0	0		0	
Кредит	0	0	0	0		0	
Дебет	0	0	0	0		0	
2. Хөрөнгийн шилжүүлэг	14	27	24	13	95%	-2	-9%
Кредит	15	27	25	12	83%	-3	-10%
Дебет	1	1	0	-1	-43%	-1	-75%
Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-107	-352	-305	-246	-230%	47	13%
III. САНХҮҮГИЙН ДАНС	-365	-355	-509	10	3%	-154	-43%
Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)	-365	-355	-509	10	3%	-154	-43%
1. Шууд хөрөнгө оруулалт	-394	-531	-469	-137	-35%	62	12%
1.1 Актив	5	2	17	-3	-57%	15	769%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	5	4	17	-1	-22%	14	389%
1.1.2 Өрийн хэргэсэл	0	-2	0	-2		1	
1.2 Пассив	399	533	486	134	34%	-47	-9%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	181	354	253	173	96%	-101	-28%
1.2.2 Өрийн хэргэсэл	218	179	233	-39	-18%	54	30%
2. Багцын хөрөнгө оруулалт	-67	238	-18	306	454%	-256	-107%
2.1 Актив	-4	15	12	19	489%	-3	-21%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-4	13	5	17	397%	-8	-64%
2.1.2 Өрийн бичиг	0	2	7	2	538%	5	
2.2 Пассив	63	-223	30	-286	-452%	253	113%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-1	-1	5	0	-24%	6	608%
2.2.2 Өрийн бичиг	64	-222	25	-286	-447%	247	111%
3. Санхүүгийн үемэл хэргэслүүд	-1	-41	2	-40	-6801%	43	106%
3.1 Актив	0	-21	2	-22	-10232%	23	109%
3.2 Пассив	1	19	0	19	2317%	-20	-102%
4. Бусад хөрөнгө оруулалт	97	-22	-25	-118	-122%	-3	-14%
4.1 Актив	-135	-14	-149	121	89%	-134	-939%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	-165	-29	-141	136	82%	-112	-385%
4.1.3 Зээл	0	-27	0	-27	-14928%	27	100%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	31	42	-8	11	36%	-49	79x
4.1.5.1 Богино хугацаат	31	42	-8	11	36%	-49	79x
4.1.5.2 Урт хугацаат	0	0	0	0		0	
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	-232	7	-124	239	103%	-131	-1794%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	52	-49	-72	-101	-193%	-24	-49%
4.2.3 Зээл	-216	58	-65	275	127%	-123	-211%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0		0	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	-218	1	-93	219	101%	-95	-7522%
4.2.3.3.1 Богино хугацаат	-75	33	3	108	144%	-30	-89%
4.2.3.3.2 Урт хугацаат	-142	-32	-97	111	78%	-65	-204%
4.2.3.2 Засгийн газар	83	133	34	50	60%	-99	-74%
4.2.3.4 Бусад салбар	-82	-76	-5	6	8%	70	93%
4.2.3.4.1 Богино хугацаат	0	-39	-26	-38	-8360%	13	34%
4.2.3.4.2 Урт хугацаат	-81	-37	21	45	55%	57	156%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-68	-2	13	65	97%	15	660%
4.2.5.1 Богино хугацаат	-68	-2	13	65	97%	15	660%
4.2.5.2 Урт хугацаат	0	0	0	0		0	
4.2.6 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0		0	
IV. Алдаа болон орхигдуулга	-169	-132	32	37	0	165	1
V. НӨӨЦ ХӨРӨНГӨ	90	-130	236	-219	-245%	366	282%
1. ГВУН	128	-93	236	-221		329	
2. ОУВС-гийн зээл	38	37	0	-2		-37	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	

* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2017	03/31/2018	06/30/2018	09/30/2018	12/31/2018	03/31/2019	6/30/2019
Гадаад хөрөнгө оруулалтын нэвэрлэлт	(32,031)	(32,686)	(32,768)	(33,292)	(33,630)	(34,345)	(34,442)
Актив	5,553	5,627	5,647	5,397	6,156	6,540	6,854
Шууд хөрөнгө оруулалт	495	519	521	525	533	545	564
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	427	447	450	455	466	477	496
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч							
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	427	447	450	455	466	477	496
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Өрийн хэргэсэл	68	72	71	70	67	68	68
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч							
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	68	71	70	69	66	68	67
Хамааралтай компани хоорондын	1	1	1	1	1	1	1
	0	0	0	0	0	0	0
Багийн хөрөнгө оруулалт	268	270	275	286	297	288	292
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	254	256	258	269	279	271	267
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	18	28	29	21	23	22	23
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	236	228	229	248	256	249	244
Бусад санхүүгийн байгууллага	168	172	184	193	210	213	218
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	69	56	45	56	46	36	26
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	14	14	17	17	18	18	25
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	6	6	6	6	7	7	9
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	8	8	10	10	10	10	16
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	6
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион	(0)	6	6	0	0	3	5
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	(0)	6	6	0	0	3	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	5
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0	0	5
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэшилүүд	0	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	1,782	1,849	1,856	1,692	1,784	2,050	1,899
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	1,328	1,477	1,441	1,292	1,283	1,517	1,374
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	461	605	643	532	461	806	660
үүнээс: Банк хоорондын позиц	0	0	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	867	872	798	759	822	711	714
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	867	872	798	759	822	711	714
Зээл	61	60	60	60	150	156	156
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	60	60	60	60	150	156	156
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	2	(0)	(0)	(0)	(0)	0	1
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	392	313	355	340	352	376	369
Бусад дансны авлага/оглог	0	0	0	0	0	0	0
Нөөц хөрөнгө	3,008	2,983	2,989	2,894	3,542	3,653	4,094

Үргэлжлэл.

Үзүүлэлт	12/31/2017	03/31/2018	06/30/2018	09/30/2018	12/31/2018	03/31/2019	6/30/2019
Гадаад пассив	37,584	38,313	38,415	38,689	39,786	40,884	41,296
Шууд хөрөнгө оруулалт	18,020	18,566	19,121	19,579	20,223	20,697	21,184
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	10,023	10,330	10,660	10,708	10,995	11,288	11,525
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	10,023	10,330	10,660	10,708	10,995	11,288	11,525
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Өрийн хэргэсэл	7,996	8,235	8,461	8,871	9,228	9,409	9,659
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	7,996	8,235	8,461	8,871	9,228	9,409	9,659
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0	0	0
Багийн хөрөнгө оруулалт	4,937	4,758	4,394	4,505	4,887	5,231	5,260
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	71	71	69	79	75	74	78
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	11	11	11	21	21	21	21
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	60	60	58	58	54	53	57
Бусад санхүүгийн байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0	0	0
Өрийн бичиг	4,866	4,687	4,326	4,427	4,811	5,157	5,182
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	589	608	596	633	624	640	632
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	3,549	3,340	2,996	3,067	2,946	2,970	2,941
Бусад салбарууд	728	738	733	726	1,241	1,547	1,610
Бусад санхүүгийн байгууллага	266	284	272	274	787	1,102	1,099
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	460	452	459	451	451	443	60
Санхүүгийн үүсмэл хэргэслүүд (нөөцөөс бусад) ба ажигчдын хувьцааны опцион	(0)	6	25	1	1	0	0
Төв банк	0	0	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	(0)	6	25	1	1	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэргэслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0	0	0
Бусад хөрөнгө оруулалт	14,628	14,983	14,875	14,604	14,675	14,956	14,852
Бусад хөрөнгө	0	0	0	0	0	0	0
Бэлэн мөнгө ба харилцах	2,245	2,365	2,210	2,101	2,123	2,199	2,086
Төв банк	1,837	1,913	1,811	1,744	1,745	1,786	1,747
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	314	330	297	317	327	402	339
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0	0	0
Бусад салбарууд	95	122	102	40	51	11	0
Бусад санхүүгийн байгууллага	95	122	25	40	51	11	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0	0	0
Зээл	12,102	12,345	12,392	12,261	12,265	12,389	12,369
Төв банк	188	224	253	252	286	287	286
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1,291	1,409	1,418	1,360	1,279	1,352	1,274
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	3,772	3,902	3,933	3,981	4,238	4,293	4,306
Бусад салбарууд	6,850	6,811	6,787	6,668	6,462	6,458	6,503
Бусад санхүүгийн байгууллага	529	517	468	417	292	300	331
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	6,322	6,294	6,319	6,251	6,170	6,158	6,172
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	280	274	273	242	288	368	396
Бусад дансны авлага/оглог	0	0	0	0	0	0	0

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР (мянган ам.доллар)

Үзүүлэлт	12/30/2016	12/31/2017	3/31/2018	6/30/2018	9/30/2018	12/31/2018	3/31/2019	6/30/2019
Засгийн газар	4,868,606	7,320,975	7,242,453	6,929,304	7,048,571	7,184,193	7,262,273	7,246,432
Богино хугацаат	-	-	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	4,868,606	7,320,975	7,242,453	6,929,304	7,048,571	7,184,193	7,262,273	7,246,432
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	-	-	-	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	2,063,528	3,548,542	3,340,397	2,995,995	3,067,325	2,946,032	2,969,549	2,940,797
Зээл	2,805,078	3,772,434	3,902,056	3,933,308	3,981,246	4,238,161	4,292,724	4,305,635
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-
Товбанк	1,790,751	2,025,079	2,136,576	2,064,703	1,995,912	2,030,222	2,072,409	2,033,926
Богино хугацаат	1,725,434	1,837,133	1,912,712	1,811,484	1,743,626	1,744,562	1,785,788	1,747,472
Харилцах, хадгаламж 5/	1,725,434	1,837,133	1,912,712	1,811,484	1,743,626	1,744,562	1,785,788	1,747,472
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	65,317	187,946	223,864	253,218	252,286	285,660	286,621	286,454
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	65,317	187,946	223,864	253,218	252,286	285,660	286,621	286,454
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-
Хадгаламжийн байгууллага (Тов банкаас бусад)	2,417,380	2,194,264	2,346,852	2,310,780	2,309,291	2,230,371	2,393,402	2,244,808
Богино хугацаат	469,093	659,008	769,008	776,745	776,901	764,047	780,225	722,054
Харилцах, хадгаламж 5/	-	313,669	330,056	296,720	316,964	326,765	401,848	338,796
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-	-	-	-
Зээл	469,093	345,339	438,952	480,025	459,937	437,283	378,378	383,258
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	1,948,288	1,535,256	1,577,844	1,534,035	1,532,389	1,466,323	1,613,176	1,522,754
Харилцах, хадгаламж 5/	239,612	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	611,048	589,222	608,231	596,325	632,753	624,396	640,020	631,704
Зээл	1,097,628	946,034	969,613	937,710	899,636	841,927	973,156	891,050
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-
Бусад салбарууд	8,121,485	7,955,844	7,944,407	7,895,491	7,676,427	8,041,874	8,384,555	8,508,661
Богино хугацаат	394,395	666,472	664,933	647,164	535,544	609,018	629,607	661,901
Харилцах, хадгаламж 5/	-	94,606	121,945	101,945	40,009	51,278	11,200	-
Өрийн бичиг 4/	2,120	2,120	2,120	2,120	2,120	2,120	2,120	2,120
Зээл	217,529	292,414	274,451	277,191	258,888	274,704	268,815	283,956
Худалдааны зээл болон урьдчилгаа	174,746	277,332	266,418	265,909	234,527	280,915	347,473	375,825
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-
Урт хугацаат	7,727,090	7,289,372	7,279,474	7,248,327	7,140,883	7,432,856	7,754,948	7,846,760
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	883,672	726,032	736,129	731,154	724,309	1,238,669	1,545,345	1,607,398
Зээл	6,801,973	6,560,413	6,536,227	6,510,054	6,409,456	6,187,069	6,189,375	6,219,135
Худалдааны зээл болон урьдчилгаа	41,445	2,927	7,118	7,118	7,118	7,118	20,228	20,228
Бусад өглөг 6/	-	-	-	-	-	-	-	-
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	7,426,277	7,996,494	8,235,177	8,460,697	8,871,427	9,228,228	9,409,118	9,659,038
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	7,426,277	7,996,494	8,235,177	8,460,697	8,871,427	9,228,228	9,409,118	9,659,038
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг	-	-	-	-	-	-	-	-
Хамааралтай компани хоорондын өглөг	-	-	-	-	-	-	-	-
Нийт гадаад өр	24,624,500	27,492,657	27,905,465	27,660,975	27,901,628	28,714,887	29,521,757	29,692,865